



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 4661

Ховд

Г Санаал, санаачилга дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2019 оныг “Хүүхдийн хөгжил хамгааллын жил болгон зарлах тухай” 60 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоол, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”-ийг баталсан 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн аймгийн нэгдсэн зөвлөгөөн”-өөс гарсан зөвлөмжийн 3.6 дахь заалтанд төрийн албан хаагчид гэр бүлдээ гаргах чөлөөт цагийг зохицуулах, хүүхдийнх нь төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгох талаар санал санаачилгыг дэмжсүгэй.

2. Хүүхдийнх нь төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгох асуудлыг байгууллагын онцлогт тохируулан Хөдөлмөрийн дотоод журам, албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг бүх шатны төрийн байгууллагын дарга нарт үүрэг болгож, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт уриалсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, иргэд олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Номинчимэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Zax A/661 Ch
02 03269